| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 710,000.00 | 0 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 469,100.00 | 81,675.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 227,700.00 | 50,574.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 73,400.00 | 0 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 203,400.00 | 200,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 138,700.00 | 74,992.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 15,700.00 | 0 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **45,518,400.00** | **43,659,980.00** |

| | | | |
|---|---|---|---|
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 44,715,000.00 | 42,856,580.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 803,400.00 | 803,400.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **46,611,600.00** | **46,611,600.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **46,611,600.00** | **46,611,600.00** |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 46,611,600.00 | 46,611,600.00 |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **283,809,900.00** | **232,556,953.00** |
| 223001 | Бусад хөрөнгө | 283,809,900.00 | 232,556,953.00 |
| **23** | **ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ** | **100,000,000.00** | **9,287,926.00** |
| 230001 | Эргэж төлөгдөх зээл | 100,000,000.00 | 9,287,926.00 |
| **III** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **1,267,279,300.00** | **1,150,291,460.70** |
| **32** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **1,086,470,900.00** | **1,094,710,787.70** |
| 320001 | Орон нутгийн төсвөөс | 828,096,300.00 | 836,336,187.70 |
| 320002 | Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих | 258,374,600.00 | 258,374,600.00 |
| **35** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | **180,808,400.00** | **55,580,673.00** |
| 350001 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 0 | 55,580,673.00 |
| 350003 | Урьд оны үлдэгдлээс санхүүжих | 180,808,400.00 | 0 |
| 4 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 0 | 27,445,733.21 |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 0 | 99,181,127.21 |
| **6** | **ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ** | 48 | **2** |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | 2 | **2** |
| 610001 | Төсвийн байгууллага | 2 | 2 |
| **62** | **АЖИЛЛАГСДЫН ТОО** | 23 | **0** |
| 620001 | Удирдах ажилтан | 10 | 0 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 10 | 0 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 3 | 0 |
| 620004 | Гэрээт ажилтан | 0 | 0 |
| **65** | **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | 23 | **0** |
| 650001 | Төрийн захиргааны албан хаагч (ТЗ) | 10 | 0 |
| 650009 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 5 | 0 |
| 650010 | Гэрээт ажилтан | 0 | 0 |
| 650011 | Улс төрийн албан хаагч (УТ) | 8 | 0 |

## 2.6 Аудит хийсэн нэгтгэсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | ТЗ цэвэр дүн |
|---|---|---|
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **41,525,105.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **41,525,105.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **41,525,105.00** |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **7,703,187.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 95,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 7,588,187.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 20,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **720,600.00** |
| 210701 | Гадаад албан томилолт | 0 |
| 210702 | Дотоод албан томилолт | 720,600.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **307,400.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 307,400.00 |

| | | |
|---|---|---|
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **32,793,918.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 32,793,918.00 |
| **I** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **41,525,105.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **41,525,105.00** |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 41,525,105.00 |

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Яруу сумын Засаг дарга нь харьяалах нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн хөгжлийн стратеги төлөвлөлт, хөтөлбөр, төслийг боловсруулах, хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий аймгийн ТЕЗ-ийн харьяа байгууллага юм.

Сумын хөгжлийн төлөвлөгөөнд 8 зорилтын хүрээнд 71 төсөл, арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөж биелэлт 72.5 хувьтай байна.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Яруу сумын Засаг дарга нь үйл ажиллагаандаа Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай, Төсвийн тухай, Төрийн албаны тухай, Хөдөлмөрийн тухай, Шилэн дансны тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай зэрэг хуулиудыг голлон мөрдөж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомжтой холбоотой Төрийн хэмнэлтийн тухай хуулийг шинээр батлан мөрдөж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна гэж үзлээ.

Дотоод хяналтыг хэрэгжүүлэх нэгж байгуулаагүй, засаг дарга төсөв зарцуулалтад тавих хяналтаа хангалттай хэрэгжүүлээгүй байна гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Яруу сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Нутгийн захиргааны байгууллагууд нь нийтлэг НББ-ын бодлогын баримт бичгийг боловсруулан үйл ажиллагаандаа мөрдөж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Яруу сумын Засаг даргын 2023 оны нэгтгэсэн санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 81,455.7 мянган төгрөгөөр буюу 10.4 хувиар өссөн байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

*/мянган төгрөгөөр/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 88,538.3 | 206,488.9 | 117,950.6 |
| Авлага | 193,063.4 | 154,155.8 | (38,907.6) |
| Бараа материал | 15,336.4 | 9,906.5 | (5,429.9) |
| Урьдчилж гарсан зардал | - | - | - |
| Үндсэн хөрөнгө | 404,196.9 | 412,039.5 | 7,842.6 |
| **Нийт хөрөнгө** | **701,135.0** | **782,590.7** | **81,455.7** |
| Өр төлбөр | 30.0 | 30.1 | 0.1 |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 701,105.0 | 782,560.6 | 81,455.6 |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **701,135.0** | **782,590.7** | **81,455.7** |

*Эх сурвалж: Яруу сумын Засаг даргын 2023 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан.*

### 3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 206,488.9 мянган төгрөг болж, өмнөх оноос 117,950.6 мянган төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл*

*/мянган төгрөгөөр/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) |
|---|---|---|---|
| Төрийн сангийн харилцах | 88,538.3 | 206,488.9 | **117,950.6** |
| Арилжааны банк дахь харилцах | - | - | **-** |
| **Дүн** | **88,538.3** | 206,488.9 | **117,950.6** |

*Эх сурвалж: Яруу сумын Засаг даргын 2023 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан.*

Мөнгөн хөрөнгө өмнөх оны үлдэгдлээс 117,950.6 мянган төгрөгөөр буурсан нь 2022 оны татварын давсан орлогоос сумын ОНХС, ЗДТГ-ын үйл ажиллагаанд төсөв баталж зарцуулсан, ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх зарим ажил хийгдээгүй үлдэгдлээр үлдсэн зэрэгтэй холбоотой байна.

*Аудитын илрүүлэлт: Мөнгөн хөрөнгөтэй холбоотой алдаа, зөрчил илрээгүй.*

### 3.5.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 154,155.8 мянган төгрөг болж, өмнөх оноос 38,907.6 мянган төгрөгөөр буурсан байна.

*Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл*

*/мянган төгрөгөөр/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) |
|---|---|---|---|
| Ажиллагчтай холбогдсон авлага | 12.6 | - | (12.6) |
| Төлбөртэй үйлчилгээний авлага | - | - | - |
| Байгууллагаас авах авлага | - | - | - |
| Хувь хүмүүсээс авах авлага | 193,050.8 | 154,155.8 | (38,895.0) |
| **Дүн** | **193,063.4** | **154,155.8** | **(38,907.6)** |

*Эх сурвалж: Яруу сумын Засаг даргын 2023 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан.*

Авлага данс өмнөх оны үлдэгдлээс 38,907.6 мянган төгрөгөөр буурсан нь Хоршоог хөгжүүлэх сангийн хувь хүмүүсээс авах авлага буурсантай холбоотой байна.

*Аудитын илрүүлэлт: Авлага данстай холбоотой алдаа, зөрчил илрээгүй.*

### 3.5.3 Урьдчилгаа

Урьдчилгаа данстай холбоотой үлдэгдэл тайланд тусгагдаагүй байна.

### 3.5.4 Бараа материал

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 9,906.5 мянган төгрөг болж, өмнөх оноос 5,429.9 мянган төгрөгөөр буурсан байна.

*Хүснэгт 4. Бараа материалын үлдэгдэл*

*/мянган төгрөгөөр/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) |
|---|---|---|---|
| **Хангамжийн материал** | **15,336.4** | 9,906.5 | **(5,429.9)** |
| Бичиг хэргийн материал | 1,246.6 | 1,198.0 | (48.6) |
| Аж ахуйн материал | 6,979.8 | 2,773.2 | (4,206.6) |
| Сэлбэг хэрэгсэл | - | - | - |
| Түлш, шатах тослох материал | 5,000.0 | 269.1 | (4,730.9) |
| Барилгын засварын материал | 1,500.0 | 1,500.0 | - |
| Бусад хангамжийн материал | 610.0 | 4,166.2 | 3,556.2 |
| Мал амьтад | - | - | - |
| **Дүн** | **15,336.4** | 9,906.5 | **(5,429.9)** |

*Эх сурвалж: Яруу сумын Засаг даргын 2023 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан.*

Бараа материал дансны эцсийн үлдэгдэл 5,429.9 мянган төгрөгөөр өссөн нь хөрөнгө оруулалтаар үнэ төлбөргүй ирсэн 3,556.2 мянган төгрөгийн бусад хангамжийн материал нэмэгдсэн, тайлант онд 59,497.4 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, 68,483.5 мянган төгрөгийн бараа материал зарцуулсан зэрэгтэй холбоотой байна.

*Аудитын илрүүлэлт: Бараа материал данстай холбоотой ЗДТГ-т алдаа, зөрчил гарсан байна. Үүнд:*
*Худалдан авсан сэлбэг хэрэгсэл, аж ахуйн материалыг данс бүртгэлд тусгаагүй 18,277.0 мянган төгрөгийн алдааг аудитын явцад залруулсан.*

### 3.5.5 Бусад эргэлтийн хөрөнгө

Бусад эргэлтийн хөрөнгөтэй холбоотой бүртгэл байхгүй байна.

### 3.5.6 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл цэвэр дүнгээр 412,039.5 мянган төгрөг болж, өмнөх оноос 7,842.6 мянган төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт 5. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл*

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) |
|---|---|---|---|
| **Биет хөрөнгө** | **396,521.4** | 400,696.5 | **4,175.1** |
| Барилга, байгууламж, орон сууц | 290,391.9 | 288,881.0 | (1,510.9) |
| Авто-тээврийн хэрэгсэл | 25,670.0 | 21,443.4 | (4,226.6) |
| Машин тоног төхөөрөмж(компьютер) | 58,935.7 | 41,816.4 | (17,119.3) |
| Тавилга, аж ахуйн эд хогшил | 11,062.8 | 7,913.2 | (3,149.6) |
| Бусад үндсэн хөрөнгө | 10,461.0 | 40,642.5 | 30,181.5 |
| Ном | - | - | - |
| **Биет бус хөрөнгө** | **7,675.5** | 11,343.0 | **3,667.5** |
| Программ хангамж | 1,377.5 | 5,045.0 | 3,667.5 |
| Бусад биет бус хөрөнгө | 6,298.0 | 6,298.0 | - |
| **Дүн** | **404,196.9** | 412,039.5 | **7,842.6** |

*Эх сурвалж: Яруу сумын Засаг даргын 2023 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан.*

Үндсэн хөрөнгө дансны эцсийн үлдэгдэл 7,842.6 мянган төгрөгөөр өссөн нь 48,918.0 мянган төгрөгөөр сумын ОНХС-ийн хөрөнгөөр худалдан авсан хөрөнгүүдийг данс бүртгэлд тусгасан, 1,000.0 мянган төгрөгөөр ИТХ-д мотор, 4,500.0 мянган төгрөгөөр ЗДТГ-т хяналт шинжилгээ, үнэлгээний программ худалдан авсан, тайлант оны элэгдлийн зардалд 46,575.4 мянган төгрөгийг тооцож, бүртгэсэн зэрэгтэй холбоотой байна.

*<u>Аудитын илрүүлэлт:</u> Бараа материал данстай холбоотой ЗДТГ-т алдаа, зөрчил гарсан байна. Үүнд:*

1. *Үндсэн хөрөнгийг зөв ангилж бүртгээгүй 33,918.0 мянган төгрөг,*
2. *Худалдан авсан биет бус хөрөнгийг санхүүгийн тайланд тусгаагүй 4,500.0 мянган төгрөгийг тус тус залруулсан.*

### 3.5.7 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн дансны эцсийн үлдэгдэл 30.1 мянган төгрөг болж, өмнөх оноос 0.1 мянган төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт 6. Нийт өр төлбөрийн үлдэгдэл*

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) |
|---|---|---|---|
| Ажилчидтай холбогдсон өглөг | - | 0.1 | 0.1 |
| Бараа үйлчилгээний зардлын өглөг | - | - | - |
| Хувь хүмүүст төлөх өглөг | - | - | - |
| Байгууллагад төлөх өглөг | 30.0 | 30.0 | - |
| Дүн | 30.0 | 30.1 | 0.1 |

*Эх сурвалж: Яруу сумын Засаг даргын 2023 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан.*

Өглөг дансны эцсийн үлдэгдэл 0.1 мянган төгрөг болж өссөн нь ажиллагсадтай холбоотой өглөг үүссэн байна.

*<u>Аудитын илрүүлэлт:</u> Өр төлбөр данстай холбоотой алдаа, зөрчил илрээгүй.*

### 3.5.8 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 782,560.6 мянган төгрөг болж, өмнөх оноос 81,455.6 мянган төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт 7. Засгийн газрын хувь оролцоо*

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) |
|---|---|---|---|
| Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 312,513.8 | 312,513.8 | - |
| **Хуримтлагдсан үр дүн** | **255,841.0** | 337,296.6 | **81,455.6** |
| Өмнөх үеийн үр дүн | 1,680,086.8 | 255,841.0 | **(1,424,245.8)** |
| Тайлант үеийн үр дүн | (1,424,245.8) | 81,455.6 | **1,505,701.4** |
| Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 132,750.2 | 132,750.2 | - |
| **Дүн** | **701,105.0** | 782,560.6 | **81,455.6** |

*Эх сурвалж: Яруу сумын Засаг даргын 2023 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан.*

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл өссөн нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

ТТЗ нь шууд захирагчдын төсвийн төслийг нэгтгэдэггүй байна. Шууд захирагч нар тус тусдаа төсвийн төслийг боловсруулан ТЕЗ-ийн холбогдох хэлтэст нэгтгүүлж байна.

Сумын ИТХ-ын 2022 оны 46 дугээр тогтоолоор ТТЗ-ийн 2023 оны төсвийн жилд зарцуулах зарлагыг 1,078,777.9 мянган төгрөгөөр баталжээ. Үүнээс орон нутгийн байгууллагын 2023 оны төсвийн жилд зарцуулах зарлагын нийт хэмжээ 874,376.9 мянган төгрөг байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 4 хөтөлбөрийн 14 арга хэмжээг санхүүжүүлэхээр 298,312.3 мянган төгрөгийг санхүүгийн дэмжлэгээс, 207,884.2 мянган төгрөгийг аймгийн ОНХС-аас сумд олгох орлогын шилжүүлгээс, Улсын төсөвт байгууллагуудын тогтмол зардал 199,401.0 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 192,372.0 мянган төгрөгийг татварын болон татварын бус орлогоос,100,000.0 мянган төгрөгийг ХХС-ийн орлогоос, 80,808.4 мянган төгрөгийг урьд оны үлдэгдлээс бүрдүүлэхээр сумын ИТХ-аар анх баталжээ.

Аймгийн 2023 оны төсвийн тодотголоор сумд олгох санхүүгийн дэмжлэгийг 134,271.3 мянган төгрөгөөр, аймгийн ОНХС-аас олгох шилжүүлгийг 50,490.4 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, баталсан байна.

Аймгийн төсвийн тодотголд үндэслэн тус сумын 2023 оны төсвийн жилд зарцуулах зарлагын нийт хэмжээг тооцоолоход 1,267,279.3 мянган төгрөг байна.

Гүйцэтгэлээр санхүүгийн дэмжлэгээс 432,583.6 мянган төгрөгийн, аймгийн ОНХС-с сумдад олгох шилжүүлгээс 258,374.6 мянган төгрөгийн, Улсын төсөвт байгууллагуудын тогтмол зардалд орон нутгийн төсвөөс 220,513.6 мянган төгрөгийн, татварын болон татварын бус орлогоос 174,999.1 мянган төгрөгийн, урьд оны үлдэгдлээс 180,808.4 мянган төгрөгийн орлого бүрдүүлсэн нь батлагдсан төсвөөс 116,987.9 мянган төгрөгөөр дутуу байна. Энэ нь аймгаас олгох санхүүгийн дэмжлэг 2,000.0 мянган төгрөгөөр дутуу олгогдсон, Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтөөс орох орлогыг төлөвлөдөггүй, урьд оны үлдэгдлээс санхүүжүүлэхээр тооцсон зэрэг нөлөөлж байна.

*Хүснэгт 8. Төсвийн гүйцэтгэл*

*/мянган төгрөгөөр/*

| Д/д | Санхүүгийн эх үүсвэр | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү |
|---|---|---|---|---|
| 1 | Санхүүгийн дэмжлэг | 432,583.6 | 430,583.6 | (2,000.0) |
| 2 | Аймгийн ОНХС-аас олгох шилжүүлэг | 258,374.6 | 258,374.6 | - |
| 3 | Татварын болон татварын бус орлого | 174,999.1 | 146,473.4 | (28,525.7) |
| 4 | Урьд оны үлдэгдэл | 180,808.4 | 38,765.6 | (142,042.8) |
| 5 | Үндсэн үйл ажиллагааны орлого | - | 55,580.6 | 55,580.6 |
| 6 | Улсын төсөвт байгууллагуудын тогтмол зардал | 220,513.6 | 220,513.6 | - |
| | **ДҮН** | **1,267,279.3** | 1,150,291.4 | **(116,987.9)** |

Татварын болон татварын бус орлогоор 241,163.0 мянган төгрөгийг бүрдүүлж татварын буцаан олголтод 23,585.4 мянган төгрөгийг, санхүүжилтэд 217,577.6 мянган төгрөгийг олгосон байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,078,556.0 мянган төгрөг буюу 85.1 хувьтай байгаа нь цалин, нийгмийн даатгалын шимтгэл, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал зардлыг хэмнэсэн, ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр баталсан зарим ажил хийгдээгүй, Хоршоо хөгжүүлэх сангаас төлөвлөсөн хэмжээнд зээл олгоогүй, ИТХ, ЗДТГ-т санхүүжилт дутуу олгосон зэрэгтэй холбоотой байна.

*Хүснэгт 9.* Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

*/мянган төгрөгөөр/*

| Д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| 1 | Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал | 108,145.8 | 86,487.2 | 21,658.6 | 80.0 |
| 2 | Засаг даргын Тамгын газар | 554,589.8 | 534,894.4 | 19,695.4 | 96.4 |
| 3 | Орон нутгийн хөгжлийн сан | 283,809.9 | 232,556.9 | 51,253.0 | 81.9 |
| 4 | Хоршоог хөгжүүлэх сан | 100,000.0 | 9,287.9 | 90,712.1 | 9.3 |
| 6 | Улсын төсөвт байгууллагуудын тогтмол зардал | 220,513.6 | 215,329.5 | 5,184.1 | 97.6 |
| | **ДҮН** | **1,267,279.3** | **1,078,556.0** | 188,723.3 | **85.1** |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

2023 онд нэмэлт санхүүжилтээр 41,525.1 мянган төгрөгийн орлого төвлөрүүлж, 41,525.1 мянган төгрөгийг тээвэр шатахуун, дотоод албан томилолт, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамж, бараа үйлчилгээний бусад зэрэгт зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Сумын хэмжээнд тусгайлан хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөр байхгүй бөгөөд сумын хөгжлийн төлөвлөгөөнд улс, аймгийн хэмжээнд хэрэгжүүлж буй "Монгол бичгийн Үндэсний хөтөлбөр-III", "Чадварлаг багш" дэд хөтөлбөр, "Чадварлаг эмч" дэд хөтөлбөр зэрэг арга хэмжээ, төсөл хөтөлбөрүүдийг тусгасан байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Яруу сумын Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Г.Баасанжаргал гүйцэтгэж, чанарын хяналтыг ахлах аудитор Ц.Оюунсувд, аудитын менежер Х.Болдбаатар, дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа нар тус тус хэрэгжүүлсэн.

Яруу сумын Засаг даргын 2023 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Завхан аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн 1/31 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогын 1,901,701.5 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 28,525.5 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 21,394.1 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, аудитыг гүйцэтгэх шатанд шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор төлөвлөгөө гаргаагүй, батлагдсан төсвийн хүрээнд зардал гарган ажилласан байна. Төсөвт бодит хэмнэлт үүссэн зардал байхгүй байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн шалгуур үзүүлэлтээс тухайн шалгагдагч байгууллагатай хамааралтай 18 заалтыг сонгож, горим сорил хэрэгжүүлсэн бөгөөд алдаа, зөрчил илрээгүй байна.

*Аудитын илрүүлэлт:* *ЗДТГ-т зөрчил гарсан байна. Үүнд: Засаг даргын нөөц сангийн хөрөнгөөс морин уралдааны телевизийн бичлэг хийлгэн зориулалт бус, үр ашиггүй зардал гаргасан 1,000.0 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоосон байна.*

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын

талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

*Аудитын илрүүлэлт: Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой алдаа, зөрчил илрээгүй.*

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил илрээгүй байна.

### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

#### 4.5.1 Завсрын аудитын талаар

Яруу сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд завсрын аудит хийгдээгүй байна.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар хариуцлага тооцох албан шаардлага хүргэгдсэн байна.

*Хүснэгт 12. Төлбөрийн акт,* албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

*/мянган төгрөгөөр/*

| Үзүүлэлт | Өмнөх аудитаар | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Акт | | | | | |
| Албан шаардлага /хариуцлага тооцох/ | 1 | 48,918.0 | 0 | 0 | 0 |
| Зөвлөмж | | | | | |
| **Нийт дүн** | **1** | **48,918.0** | **0** | **0** | **0** |

Өмнөх аудитаар хариуцлага тооцох албан шаардлага хүргэгдсэн ч хэрэгжээгүй байгаа тул дараагийн шатны төсвийн захирагчид шилжүүллээ.

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал тодорхойлогдоогүй байна.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар алдаа, зөрчил илрээгүй болно.

### 5.1 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоох алдаа, зөрчил илрээгүй болно.

### 5.2 Албан шаардлага

Аудитаар төлбөрийн акт тогтоох алдаа, зөрчил илрээгүй болно.

**5.3 Зөвлөмж**

Аудитаар зөвлөмж өгөх алдаа, зөрчил илрээгүй болно.

**Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.**

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

o

*/мянган төгрөгөөр/*

| Байгууллагын нэр | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруу-лаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| | | | | | | | | | | | | |
| **Дүн** | | | | | | | | | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

*/мянган төгрөгөөр/*

| Байгууллагын нэр | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | АТТ | Тоо | Дүн |
| | | | | | | | | | | | | |
| **Дүн** | | | | | | | | | | | | |

**АУДИТЫН ТАЙЛАНГ:**

**ХЯНАСАН:**

ДАРГА,ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Д.БАТ-ҮНДРАА

АУДИТЫН МЕНЕЖЕР Х.БОЛДБААТАР

**БОЛОВСРУУЛСАН:**

АУДИТОР Г.БААСАНЖАРГАЛ

Огноо: 2024-03-14